

1. Улаан малгайтын ээж нь эмээгийнхээ гэрт хүрхэн хүрэхийг доорх заавраар хэлж өгчээ. Улаан малгайтыг эмээгийнхээ очиход нь тусал.



2. Хэсэг хүүхэд хэдэн тугалыг тууж явна. Нийт 30 хөл, 6 сүүл байсан бол тугал ба хүүхэд хэд байсан бэ?

3. Болд, Бат алимаа хувааж авч чадсангүй. Хэрвээ дөрөв, дөрвөөр нь хувааж авбал нэг алим илүү гарна. Харин тав, таваар нь авбал нэг алим дутна. Тэдэнд хэдэн алим байсан бэ?

4. Хонгор Тэлмүүн нар 3 кг чихэр авахыг хүсчээ. 5 кг ба 2 кг-ийн туухайг ашиглан 3 кг чихрийг жигнэж өгч болох уу?



5. Доорх зургаас 4 хос хутгыг ол.



6. Хоёр хүүхдэд хэд хэдэн алим байжээ. Эхний хүүхэд хоёр дахь хүүхдэд нэг алим өгвөл тэдний алим тэнцүү болно. Харин хоёр дахь хүүхэд эхний хүүхдэд нэг алим өгвөл эхний хүүхэд хоёр дахь хүүхдээс хоёр дахин олон алимтай болно. Тэд тус бүр хэдэн алимтай байсан бэ?

7. Хүснэгтийн бүх нүднүүдийг нэг удаа дайран А цэгээс Б цэгт хүрэх замыг ол.

А					
					Б

8. Дараах оньсогуудыг таа.

- Эгч нь зочилж ирэхэд дүү нь нуугдчихдаг. Тэр юу вэ?
- Ойд төрсөн, усанд амьдардаг. Тэр юу вэ?
- Авахад хар байдаг. Хэрэглэхэд улаан болдог. Хэрэглэж дууссаны дараа улаан болдог. Тэр юу вэ?
- Авахад хөнгөн байдаг. Хэрэглэж дууссаны дараа хүнд болдог. Тэр юу вэ?


9. Нэг мөр, багана, диагоналийн дагуу байгаа хүүхдүүдэд ямар ерөнхий зүйлс байна вэ? Жишээ нь: Баруун диагоналийн дагуу байгаа хүүхдүүд бүгд цанын тулгуур барьжээ.



10. Дараах оньсогуудыг таа.


- Махгүй, ясгүй. Тэгсэн мөртлөө 10 хуруутай. Тэр юу вэ?
- Олон гартай. Нэг хөлтэй. Тэр юу вэ?
- Шөнө газар унтдаг. Өглөө тэнгэр лүү нисдэг. Тэр юу вэ?
- Өглөө дөрвөн хөлтэй. Өдөр хоёр хөлтэй. Харин үдэш гурван хөлтэй болдог. Энэ ямар амьтан бэ?
- Эхлээд доош шиддэг. Дараа нь дээш татаж гаргаж ирдэг. Тэр юу вэ?
- Эхлэлгүй, төгсгөлгүй. Тэр юу вэ?
- Юу оюун бодлоос илүү хурдан бэ?

14. Түлхүүрүүдийг тохирох цоожтой нь холбож зур.



15. Бүтэн дөрвөлжин үүсгэхэд доорх дүрсүүдийн аль нь оролцох вэ?

16. Доорх зурагт юу юуны зураг байна вэ?




17. Доорх зургаас 0-9 хүртэлх цифрүүдийг ол.



18. 6 мууртай нэгэн хүү байжээ. Хүү муурнууддаа өгөхөөр дэлгүүрээс 3 годон хиам, 3 талх авчирчээ. Муурнууд бүгд л хиам, талх идэхийг хүсэж, хоорондоо муудалцав. Авчирсан зүйлсийг тэдэнд хэрхэн хувааж өгөх вэ?

19. Доорх зурагт юу юуны зураг байна вэ?




20. Дараах асуултуудад аль болох хурдан хариул.

- Нар хаана жаргадаг вэ?
- Ямар зүйлс усанд живдэг вэ?
- Ямар зүйлс усны гадарга дээр хөвдөг вэ?
- Ямар амьтан өвөл цагаан, зун саарал өнгөтэй болдог вэ?
- Ямар амьтан намар өмнө зүг рүү нисдэг вэ?
- Нар хаанаас манддаг вэ?
- Өвчтөнийг хэн эмчилдэг вэ?
- Шөнө ойд ямар амьтан дуугараад байдаг вэ?
- Номыг юугаар хийдэг вэ?
- Мэлхий хаана амьдардаг вэ?

21. Доорх зургаас 10 ширхэг 2-ын цифрийг ол.



22. Гурван шулуун шугамаар чоно, ямаа, байцааг тусгаарла.




23. Нэг илжигэнд 2 шуудай гурил ачдаг бол тийм 7 шуудай гурилыг хэдэн илжигэнд ачих вэ?

24. Нэг эмэгтэй гудамжинд яваа нэгэн хүүхдэд хандан “Би чиний ээж, гэхдээ чи миний хүү биш л дээ” гэжээ. Энэ юу гэсэн үг вэ?


25. ХААН гэсэн үгийг хэдэн янзаар уншиж болох вэ?

ХААН
ААН
АН
Н

26. Дөрвөн шулуун шугамаар хулгануудыг муурнуудаас тусгаарла.



27. Доорх 4 жимсийг 3 шулуун шугамаар холбо.



28. Хувцасных нь ерөнхий төсөөгөөр аль хүүхэд аль хүний хүүхэд болохыг тодорхойл.



29. Доорх зурагт мөр, багананаар тоонуудыг бичжээ. Тэдгээр тоонуудаас 15 тоог үлдэх тоонуудыг мөрийн дагуу нэмэхэд 14, багананы дагуу нэмэхэд 10 байхаар дар.



30. Акул нэг загасыг иджээ. Тэр аль загасыг идсэн бэ?



31. Алимаа, Анхаа хоёрт нэг нэг улаан харандаа байв. Анхаа харандаагаа Хонгорт өгөв. Одоо хүүхдүүдийн хэн хэнд нь харандаа байгаа вэ?

32. Бат, Болд хоёр ерөөнд орж ирэхэд араас нь Тэлмүүн орж ирэв. Дараа нь Болд, Тэлмүүн хоёр ерөөнөөс гарав. Өрөөнд хэн үлдсэн бэ?

33. Цэнгэл Бат, Дулмаа хоёрын зөөсөн сандлуудыг нийлүүлсэнтэй тэнцэх тооны сандал зөөв. Хэн илүү олон сандал зөөсөн бэ?

34. Өчигдөр маргааш байсан. Маргааш өчигдөр байна. Тэр юу вэ?

35. Хэний сүүдэр буруу зурагдаж вэ?



36. Нэгэн эмэгтэй нэг жилийн нэг сар нэг цагт төрсөн хоёр хүүтэй гэнэ. Гэхдээ хүүхдүүд хоёр ихэр биш бол ийм байх боломжтой юу?

37. “Цагаан өнгөтэй, хөнгөн” тэр юу вэ? 2 минутын дотор энэ оньсогод тохирох аль болох олон хариуг олж бич.

38. Спортын дэлгүүрт хуурай буурцагаар дүүргэсэн бөмбөг зардаг гэнэ. Яагаад ийм бөмбөг зардаг юм болоо? Ийм бөмбөг юунд хэрэгтэй вэ?

39. Доорх зурагт байгаа 10 алдааг ол.



40. “Өнөөдөр өгөөд маргааш авна. Тэр юу вэ?” 2 минутын дотор энэ оньсогод тохирох аль болох олон хариуг олж бич.

41. Жек өөрийн дүүг жирэмсэн эхнэрийнх нь хамт идчихжээ. Гэвч Жек ямар ч шийтгэл хүлээгээгүй. Яагаад тэр вэ?

42. Нэгэн эмэгтэй тавгийн чихэр худалдан авчээ. Хүүгээ идчихэж магадгүй гэж бодоод, авсанаа чихрээ нуусан байна. Хүү нь ээжийгээ чихэр худалдан авсныг мэдээд түүнийг олж идэхээр гэртээ хайгаад хайгаад олсонгүй. Ээж нь чихрээ хаана нуусан бэ?

43. Эртний хаант улсад тавтай морил. Чиний аялал хааны ордноос эхлэх бөгөөд тэндээс гараад бусад шилтгээнүүдээр нэг нэг орж, эргээд хааны ордонд ирэх ёстой. Чи аялалаа 5 зоостойгоор эхлэх бөгөөд шилтгээнээс шилтгээн орох замдаа тодорхой тооны/зам дээр бичигдсэн тоо/ зоос төлнө. Тухайн шилтгээнд хүрэхэд эзэн чамайг хоол ундаар дайлж, амраагаад дараа нь зоос нэмж өгнө/Тоо нь шилтгээний зураг дээр байна/. Хааны ордонд эргэж ирэхэд нэг ч зоос үлдээгүй байх ёстой бол аль замаар явах вэ?



44. Онъсого:

Зүү байгаад утасгүй

Утас байгаад зүүгүй

Гал байгаад илчгүй

Энэ онъсогод ямар гурван амьтны талаар өгүүлж байна вэ?

Алтан толь нь халуун

Мөнгөн толь нь хүйтэн Энэ юу вэ?

Өвсний үзүүрт

Өндөг тогтжээ Тэр юу вэ?

45. Доорх зурагт хэдэн хүн байна вэ?



46. Доорх 2 зургаас 7 ялгааг ол.




47. Муур хэнийг хулгайлсан бэ?



48. Доорх зургуудыг тохирох дүрс тэмдэгтэй нь холбо. Яагаад тэгж холбосноо тайлбарла.



49. Эхний зургаас ямар ямар зүйлс хоёр дахь зурагт алга байна вэ?



50. Онъсого:

Аав нь амгалан тайван

Ээж нь цэнгэл сайхан

Хүүхэн нь гунхал сайхан

Хүү нь ширүүн хар

Энэ юу вэ?

Үүлгүй байтал бороо орох

Өвөл биш байтал цас орох

Энэ юу вэ?

Эрээн дээсийг

Эвхэж болдоггүй

Энэ юу вэ?

Хэл бүгдээр ярьдаг хүн

Хэн бүхнийг дуурайдаг хүн

Энэ юу вэ?

Тэсгэм өвөл

Нүцгэн мөртөө

Дэлгэр зун

Дээлээ нөмөрнө


Энэ юу вэ?

Гараар нэхээгүй

Гайхамшигтай тор

Энэ юу вэ?

51. Доорх зургаас заасан зүйлсийг хайж олоод, өнгөөр ялган буд.




1. Улаан малгайт



2. Хариу: 6 тугал, 3 хүүхэд


3. Хариу: 9 алим

5. Хос хутга



6. Хариу: 7 ба 5

7.



8. Хариу: нар ба сар; завь; нүүрс;

хүүхдийн живх

9. Ерөнхий зүйлс:

Хэвтээ:

1-р эгнээний хүүхдүүд бүгд

судалтай хувцас өмсчээ

2-р эгнээний хүүхдүүд бүгд захтай

хувцас өмсчээ

3-р эгнээний хүүхдүүд бүгд

бээлийтэй байна

Босоо:

1-р багананы хүүхдүүд бүгд

адилхан уруултай байна.

2-р багананы охидууд бүгдээрээ

үсэндээ тууз зүүжээ.

3-р багананы хүүхдүүд бүгд

малгайтай байна.

Зүүн диагоналийн дагуух бүх хүүхдүүд нүдний шилтэй байна.

10. Хариу: бээлий; мод эсвэл өлгүүр; шүүдэр; хүн; худгаас ус татах; цагираг; цаг хугацаа

11. Загас



12. Том тоо

98432

13.


Бүтэн дөрвөлжин

үүсгэхэд орох дүрсүүд

орохгүй дүрсүүд



14. Цоож



15.


Бүтэн дөрвөлжин үүсгэхэд орох дүрсүүд орохгүй дүрсүүд



18. Хариу: Муур бүрт тал годон хиам, тал талх өгнө.

20. Хариу: баруун зүгт; уснаас хүнд зүйлс; уснаас хөнгөн зүйлс; туулай; шувуу; зүүн зүгээс; эмч; шар шувуу; цаасаар; намагт

22. Чоно ямаа байцаа




23. Хариу: 4 илжигэнд


24. Хариу: Тэр хүүхэд тэр эмэгтэйн охин нь юм байна.

25. Хариу: нийт 8 янзаар

26. Муур ба хулгана



27. Дөрвөн жимс



29. Тоо дарах

3	1	7	5	2	6	4
7	4	2	1	5	3	6
2	3	6	7	1	5	4
5	7	3	6	4	2	1
2	6	1	4	3	5	7

31. Хариу: Алимаа, Хонгор хоёрт улаан харандаа байгаа

32. Хариу: Өрөөнд Бат үлдсэн.

33. Хариу: Цэнгэл

34. Хариу: өнөөдөр

36. Хариу: Болно. Тэр эмэгтэй гурван ихэр хүүхэдтэй. Эдгээрийн нэг нь охин.

37. Хариу: Хамгийн олон хариу бичсэн нь ялагч болно.

38. Хариу: Энэ бол хараагүй хүмүүст хөлбөмбөг тоглоход нь зориулагдсан бөмбөг юм.

40. Хариу: хамгийн олон хариу бичсэн нь ялагч болно.

41. Хариу: Жек бол бие биенийгээ иддэг нэгэн төрлийн загас юм.

42. Хариу: хажуу айлдаа

43. Хааны ордон



44. Хариу: зөгий, аалз, гэрэлт цох; /Энэ оньсогот гурван амьтныг өөр хооронд нь жишиж, нэгэнд байхгүй дутуу юиыг нөгөөд нь байхгүй илүү юмаар нөхөж оньсоголсон байна/

нар, сар; өвсний шүүдэр

45. Хариу: 15

47. Туулайг

50. Хариу: жилийн дөрвөн улирал; шүүдэр, хяруу унах; солонго; цуурай; мод; аалзны тор